

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 5/05

Мандалговь

┌ Жалбуу овогтой Батбилэгийг мал үржлийн ┐
албаны даргаар томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/209 дугаар тушаалын 10 дугаар хавсралт, Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/30 дугаар тушаалын хавсралт, Төрийн албаны салбар зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 07 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 05/2093 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Жалбуу овогтой Батбилэгийг мал үржлийн албаны дарга бөгөөд Аймгийн Ерөнхий мал зүйч, мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, технологийн хяналт хариуцсан мэргэжилтнээр 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн томилсугай.

Хоёр. Ж.Батбилэгийн үндсэн цалинг Засгийн газрыг 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг үндэслэн ТЗ-7-3 ангилалаар 836096 төгрөг, төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 18 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Энхдөл)-д зөвшөөрсүгэй.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2019 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн Б/11 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.МӨНХЖАРГАЛ

481200022